



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 16 өдөр

Дугаар A/307

Арвайхээр сум

Бүх тендерээс татгалзах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3, 48 дугаар зүйлийн 48.2.4, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны хуралдааны 2024 оны 04 дүгээр сарын 019-ны өдрийн 20 дугаар дүгнэлтийн дагуу БШУЯ/20240101131/01/01 урилгын дугаартай Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 50 ор (Өвөрхангай, Бүрд сум, 5 дугаар баг) ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт шаардлагад нийцсэн тендер ирээгүй тул бүх тендерээс татгалзсугай.

2. Тендер шалгаруулалтыг хуулийн дагуу дахин зохион байгуулахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Худалдан авах ажиллагааны газар (Ц.Идэрсайхан)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

И.ДОРЖСҮРЭН



6224 11 0836

D:My Doc. Zahiramj. Zasag darga